

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 сарын дугаар 08

Мандалговь

Зорилт	д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /жилийн эцэс/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэйн хувь
1	2	3	4	5	6	7	8	9
<b>Стратегийн төлөвлөгөөний зорилго:</b> <i>Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74,03 байсныг 2025 онд 75,0-д хүргэнэ.</i>								
<b>НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>Зорилт</b>	<b>1</b>	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 2020 онд 83.0 байсныг 2024 онд 85.0 хүргэнэ.	Хандив тусламж 20,0 сая, Улсын төсөв 2,234,700 сая ОНХС 61,0 сая	Чанарын үзүүлэлтийн хувь	59.9	70.0	Аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 58 төрлийн нийт 2,234,700 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгогдож эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 80,0 хувьд хүрсэн.	100
<b>Арга хэмжээ</b>	1.1	Алслагдсан сум, багийн малчин иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байх.	ОНХС 20,0 , Глобаль төсөл 2,8 сая	Нарийн мэргэжлийн эмч нарын явуулын үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь	3,0	8,0	Улаанбаатар хотын Лев-Мед ХХК-ний эмнэлэгтэй хамтран Хулд, Адаацаг, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад дотор, эмэгтэйчүүд, ЭХО, уушиг харшил, зүрх судасны цахилгаан бичлэг, оношилгоо,үзлэгийг нийт 3344 иргэдэд хийлээ. Нийт үзүүлсэн иргэдийн 62,0 хувь нь ковидын дараах хам шинж, 29 хувь нь амьсгалын замын үрэвсэл, 10,1 хувь нь тоосны харшил, 9,7 хувь нь арьсны харшил, 32,5 хувь нь даралт ихсэх, 20,0 хувь нь цээжний бах, 23,9 хувь нь бөөрний үрэвсэл, 21,9 хувь нь нойр булчирхайн үрэвсэл, 19,7 хувь нь ходоодны архаг үрэвсэл тус тус оношлогдсон байна.	100

							Бөөрний хавдар 3-ийг илрүүлэн 3 дахь шатлалын эмнэлэгт илгээлээ. Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая, Глобал сангийн 2,8 сая нийт 22,8 сая төгрөгийн санхүүжилтээр 9 суманд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын идэвхтэй илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, бэлгийн замаар дамжих халдвар болон ХДХВ/ДОХ-ын илрүүлэх шинжилгээ, сүрьеэ 1604 иргэнээс шинжилгээ авч тэмбүүгийн халдвар эерэг 150 тохиолдол, баталгаажуулах шинжилгээгээр хуучин халдварын 136 тохиолдлыг тогтоож, шинэ 14 тохиолдлыг илрүүлэн 100 хувь эмчилгээнд хамрууллаа. Үзлэг оношилгоо эмчилгээнд нийт 6524 иргэд хамрагдсан бөгөөд өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилтийн хувь 30. Нарийн мэргэжлийн эмч нарын явуулын үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь 13,7, нийт давхардсан тоогоор 14 суманд үзлэг хийсэн.	
1.2	Эм, хэрэгслийн сайжруулах эмнэлгийн хангалтыг	Улсын төсөв 150,0 сая	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь	84,0	84,5	Эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний төрлийн дагуу зайлшгүй шаардлагатай эм болон эмийн чанар аюулгүй байдлыг ханган тасралтгүй хүртээмжтэй хүргэж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг цахим хэлбэрт бүрэн шилжүүллээ. Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/625 дугаар тушаалаар батлагдсан зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 84,5 хувьтай,	100	
			Амин чухал эмийн хангалтын хувь	93,0	93,2	Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн амин чухал эмийн хангалтын дундаж 93,2% Преднизолон тариа тасалдал үүсээд байна.		
1.3	Эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлэлд хамруулах.	Улсын төсөв 2,8 сая	Хамрагдсан байгууллагын тоо	4	13	2022 онд магадлан итгэмжлэлд орох эмнэлгүүдийн бэлтгэл ажилд үнэлгээ хийх-Эрүүл мэндийн газрын даргын удирдамжийн дагуу ажлын хэсэг давхардсан тоогоор 17 сумдын эрүүл мэндийн төвүүдэд магадлангийн бэлтгэл ажлын үнэлгээг хийж, мэргэжлийн арга зүйн зөвлөмжийг өгсөн.	100	

	1.4	Хот хоорондын зам дагуух Дэлгэрцогт, Луус, Хулд сумдад яаралтай тусламжийн цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах.	Улсын төсөв 3,6 сая	Тусламж үзүүлсэн иргэдийн тоо	4	13	Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулан тогтмолжуулж авто осол 32, бусдад зодуулсан 8, хугарал бэртэл 7, нохойд уруулсан 5, түлэгдэлт 6, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 7, угаартсан 1, ахуйн осол 4 мориноос унасан-2-ийг тус тус эмчлэж, нийт 72 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.	100
	1.5	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний чиглэлээр сумдад ажлын байрны сургалт зохион байгуулах.	Улсын төсөв 1,0 сая	Сургалт зохион байгуулсан сумдын тоо	0	4	Анхан шатны тусламж, үйлчилгээнд орчин үеийн анагаах ухааныг уламжлалт анагаах ухаантай хослуулан хэрэгжүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд “Зонхилон тохиолдох өвчний үед уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг нэвтрүүлэх нь” сэдэвт ажлын байрны дадлагажуулах сургалтыг Хулд, Луус, Дэлгэрхангай, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан сумдын эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулж, сургалтад 5 их эмч, 6 сувилагчид хамруулж дадлагажууллаа. Нийт 6 сумын 11 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдав.	100
	1.7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилтыг сайжруулах. (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)	Улсын төсөв 15,1 сая	Ээлтэй орчин бүрдүүлсэн эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийн эзлэх хувь	90,0	95,0	Гурвансайхан, Хулд, Сайхан-Овоо, Адаацаг Нэгдсэн эмнэлэг зэрэг 14 эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд 15,1 сая төгрөгөөр шинээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан нэмэлт тохижуулалт хийсэн байна. Эрүүл мэндийн байгууллагууд гадаад болон дотоод орчноо хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлэн ажиллаж нийт эрүүл мэндийн байгууллагын 95,3% нь ээлтэй орчин бүрдүүллээ.	100
<b>Зорилт</b>	2.	Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан 5 хүртэлх насны хүүхдийн	Улсын төсөв 130,0 сая Хандив	Эхийн эндэгдлийн түвшин /100000 амьд төрөлтөд/	0	0	Эхний 11 сарын байдлаар нийт 624 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 94,7 хувь нь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрсөн. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй.	100

		эндэгдлийн түвшинг бууруулна.	тусламж 5,3 сая	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг түвшин / 1000 амьд төрөлтөд/	15.2	14.0	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 9,6 промиль байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,6 промилиор буурсан үзүүлэлттэй байна.	
<b>Арга хэмжээ</b>	2.1	Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрт үеийн хяналтыг нэмэгдүүлэх	-	Жирэмсний эрт хяналтын хувь	88,8	90.0	Жирэмсний хяналтын чанарын сайжруулах ажлын хүрээнд аймгийн төвийн 2 өрх, Дэрэн сумын эрүүл мэндийн төвийн эх баригчдыг “Ажлын байрны дадлагажуулах 10 хоног”-ийн сургалтад цахимаар 2, танхимын сургалт 1 удаа тус тус хамрууллаа. Жирэмсэн эмэгтэй бүрийг нэрээр хянах тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Баянхонгор аймагт туршлага судлах ажлын удирдамж, хөтөлбөрийг боловсруулж, Эрүүл мэндийн газрын даргын 02/171 албан бичгээр эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлээ. Жирэмсний хяналтад шинээр 623 жирэмсэн эх хамрагдснаас жирэмсний эрт үеийн хяналт 93,3 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100
	2.2	Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Туршлага	Улсын төсөв 3,0 сая	Хамрагдсан мэргэжилтний тоо	15	-	САНДОЗ” эмийн компанитай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдэд “Эх барихуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нь” туршлага солилцох уулзалтыг 10 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулж, уулзалтад Эх	100
		солилцох уулзалт”-ыг зохион байгуулах.					барих судлалын тэнхимийн тэргүүн, АУ-ны доктор, Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх зэргийн эмч Б.Мөнхцэцэг урилгаар оролцлоо. Уулзалт, сургалтад нийт 50 эмч, мэргэжилтнийг хамруулж, харилцан мэдээлэл солилцлоо.	
	2.3	Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулах.		Үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь	58.7	80.0	Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт хамрагдвал зохих 1352 хүүхдээс 598 хүүхэд буюу 44,2% хамрагдаж, үүнээс 8 хүүхдийг нарийн мэргэжлийн эмчид илгээж эмчлэн эрүүлжүүлсэн байна.	0

Зорилт	Халдварт бус өвчлөлийн түвшинг 2020 оны 7441.5 байсныг 2024 онд 7241.5 болгож бууруулна.		Улсын төсөв 18,2 сая, Монпен төсөл 4,5 сая	10000 хүн амд ногдох халдварт бус өвчлөлийн түвшин	7441.5	7341.5	Халдварт бус өвчлөлийн түвшин 10000 хүн амд 7281,5 байна.	100
3.1	Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчинг бүрдүүлэх.	Улсын төсөв 1,5 сая	Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо	33	43	“Эрүүл мэндээ дээдлэгч иргэн” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, журам, шалгуур үзүүлэлтийн дагуу идэвхитэй дасгал хөдөлгөөн, эрүүл зөв хооллолтыг дадал хэвшил болгосон 11 хүнийг шалгарууллаа. Эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 44 боллоо.	100	
Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо			16	17	“Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”, “Эрүүл ажлын байр шалгаруулах болзол, шалгуурын дагуу материалаа ирүүлсэн Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн материалд газар дээрх үнэлгээг хийсэн. Тус байгууллага нь Эрүүл мэндийг дэмжигч байгууллага II зэргийн болзол ханган шалгарсан. Ингэснээр Эрүүл мэндийг дэмжигч байгууллага 38 болж нэмэгдэв.			
3.2	Хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийг бууруулах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ЭМДС 94,9 сая Улсын төсөв 1,5 сая	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын хувь	31,0	33.6	Аймгийн хэмжээнд эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтын хувь 34,2 байна.	66.6	
Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь			64,9	65,0	Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12078 иргэнээс 7839 буюу (64,9%), чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 12974 иргэн хамрагдахаас 7810 буюу (60,2%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2568 иргэн хамрагдахаас 1610 буюу (62,6%), хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 8449 иргэн хамрагдахаас 4993 буюу (59,1%) хамрагдаж, аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 61.7%-тай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензитэй 68, чихрийн шижинтэй 9 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авлаа.			

				Эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь	59.4	60,0	Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу “Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Эрчүүдээ хайрлая”, “Давсны хэрэглээгээ багасгая”, “Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус”, “Архи, тамхи хорт зуршлаас татгалзъя”, “Сүрьеэтэй тэмцэх”, “ДОХ-ын өдөр” “Эрүүл мэндийн сар”, “Коронавирусын халдвар, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцины ач холбогдол” зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 18350 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 59 удаа сургалт зохион байгууллаа. Иргэдэд эрүүл амьдралын зөв зан үйл төлөвшүүлэх зорилгоор “Илүүдэл жингүй Эртэч Монгол” 3 сарын аян, “Зөвийг хэвшүүлье” 45 хоногийн аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн давхардсан тоогоор 37679 иргэнийг хамруулан, нийт давхардсан тоогоор 56029 хүнд эрүүл мэндийн боловсрол олгож эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь 100	
3.3	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх, эрүүл мэндийн төв бий болгох шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв 0,800,0	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувь	30,4	34.0	“Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрх” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, шалгуур үзүүлэлтийн дагуу 13 өрх айл материал ирүүлснийг хүлээн авч дүгнэлээ. Болзол уралдааны шалгуурыг хангасан 5 өрхийг тус тус шагнаж урамшууллаа. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай айл өрхийн хувь 32,0 хувь болсон байна.	0	
			Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн төвийн тоо	8	12	“Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай Эрүүл мэндийн байгууллага ” шалгаруулах болзолт уралдааныг зарлаж, шалгуур үзүүлэлтийн дагуу 3 эрүүл мэндийн байгууллага материал ирүүлснийг дүгнэж урамшууллаа. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллагын тоо 12		

<b>Зорилт</b>	4	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 2,347,800 Хандив тусламж 20,9 сая	Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ (сая.төг)	4,8 тэр бум	500,0 сая	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 2,347,800 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.	100
<b>Арга хэмжээ</b>	4.1	Заавал хийх товлот болон нэмэлт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх.		Дархлаажуулалтын хамралтын хувь	95,1	95.5	Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс товллын болон нэмэлт дархлаажуулалтад шаардлагатай вакцин, биобэлдмэл, тариур дагалдах хэрэгслийг улирал тутамд татан авч аймгийн хэмжээний нөөцийг бүрдүүлэн тасалдал үүсгэлгүй ажиллалаа. Товлолын дархлаажуулалтын үйл ажиллагааг Нэгдсэн эмнэлэг 1, сумын эрүүл мэндийн төвийн 15 дархлаажуулалтын цэгээр тус тус зохион байгуулж өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шинээр дархлаажуулалтын 2 цэгийг нээж, аймгийн хэмжээнд дархлаажуулалтын 18 цэгтэй боллоо. 2022 оны 10 сарын байдлаар заавал хийх товллын дархлаажуулалтын хамралт 95,6 хувь байна.	100
	4.2	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэн эм эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах.	Улсын төсөв 1,4 тэр бум	Эм, эмнэлгийн хэрэгслэлийн нөөцийн хангалтын хувь	73,0	80,0	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 373 дугаар тушаалын дагуу томуу, томуу төст өвчин, коронавирусын халдварын тандалтын тогтолцоог нэгтгэн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 3372 бүртгэгдсэн ба тухай бүр хяналтад авч эмчлэн эрүүлжүүллээ. 3372 тохиолдолд тандалт судалгааг 100% хийн, хавьтлуудыг хяналтад шилжүүлж ажиллалаа. Томуугийн харуулдан тандалтын мэдээг 7 хоног тутамд нийт эрүүл мэндийн байгууллагуудаас татан авч, дүгнэлт хийн хариу арга хэмжээг авсан. 2022 оны 48 дугаар 7 хоногийн мэдээгээр аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөл амбулаторийн үзлэгт 14,5%, дуудлагын үзлэгт 23,6%-тай, аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчлөлийн тархалтын түвшин “Идэвхжлийн	100

							түвшин"-д байна. Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалтын хувь 89.6 хувь байна.	
				Хүний нөөцийн бэлэн байдлын хангалтын хувь	96,8	97,0	Хүний нөөцийн хангалт 96,8%-тай байна.	
<b>Зорилт</b>	5.	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	Хандив тусламж 80,0 сая, Улсын төсөв 2,234,700 сая ОНХС 61,0 сая	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	87,0	87,9	Аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээнд 58 төрлийн нийт 2,234,700 сая төгрөгийн тоног төхөөрөмж олгогдож эмчилгээ үйлчилгээнд ашиглаж байна. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 90,6 хувь.	100
<b>Арга хэмжээ</b>	5.1.	Лавлагаа шатны эмнэлгийг оношилогоо, эмчилгээний тоног өхөөрөмжөөр хангах	Хандив тусламж 2,5 сая Улсын төсөв 2,041,100 сая	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	91,8	92,0	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийн үйл ажиллагаанд зориулан 1,152,200 тэрбум төгрөгийн зөөврийн ЭХО аппарат, тархины доплер, чих хамар хоолойн эмчийн иж бүрдэл зэрэг 41 төрлийн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11 нэр төрлийн 370,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн сайд орон нутагт ажиллахдаа 51,8 сая төгрөгийн ЭХО аппарат, “Хүннү ресорус” ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 2,5 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч тус тус олгосон. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 92.6 хувь	100
	5.2.	Анхан шатны эмнэлгүүдийг оношилогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах	Хандив тусламж 17,5 сая, Улсын төсөв 644,7 сая ОНХС 61,0 сая	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмжийн хангалтын хувь	79,2	80,0	Өрх, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд биохими, бүрэн болон хагас автомат анализатор, 3 партын гематологийн анализатор, EliZa уншигч, гүн хөлдөөгч, шүдний кресло/ком/, автоклав зэрэг 40 нэр төрлийн 644,7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 61,0 сая төгрөгийн, “Хүннү ресорус” ХХК-н нийгмийн хариуцлагын хүрээнд 17,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус олголоо. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийн хангалт 88,5 хувь боллоо.	100



	5.3	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд автомашины парк шинэчлэлтийг хийх.	Улсын төсөв 316.5 сая	Автомашины хангалтын хувь	92,0	92,1	Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийх ажлын хүрээнд Дэлгэрхангай, Луус сумдын Эрүүл мэндийн төвд улсын төсвийн 92,9 сая төгрөгийн санхүүжилттэйгээр Фургон автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 157,6 сая төгрөгийн иж бүрэн тоноглогдсон автомашин, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, Эрдэнэдалай, Хулд сумдын Эрүүл мэндийн төвд улсын төсвийн 66,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Probox суудлын автомашиныг шинээр тус тус олголоо. Автомашины хангалтын хувь 98,3 хувь.	100
<b>ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ</b>								
<b>Зорилт</b>	1	Төрийн албан хаагчийн сургалтад хамрагдалтыг 2021 онд 95.0 байсныг 2022 онд 100 хувьд хүргэнэ.		Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн хувь	95.0	100	Төрийн албан хаагчийн сургалтад хамрагдалтыг 95,0 хувьд хүрсэн.	100
<b>Арга хэмжээ</b>	1.1	Статистикч эмч нарт "HInfo.mn программ хангамж мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах нь" сэдэвт сургалт зохион байгуулах.	-	Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний нарын тоо	0	-	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн статистикч эмч нарт "HInfo.mn программ хангамжинд гарсан өөрчлөлт, мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах нь" сэдэвт 1 өдрийн сургалтыг 2022 оны 4 сарын 8-нд цахимаар зохион байгуулж нийт 27 хүн хамрагдлаа.	100
	1.2.	Төрийн албан хаагчыг монгол бичгийн багц сургалтад хамруулж "Батламж" гардан авсан байх.	-	Батламж гардан авсан төрийн албан хаагчийн хувь	8,0	85,0	Төрийн албан хаагчыг монгол бичгийн багц сургалтад хамруулах зорилгын хүрээнд 14 хоног сургалтад хамрагдаж албан хаагч нар "Батламж"-аа сургагч багшаас гардан авсан. Батламж авсан төрийн албан хаагчийн хувь 92,5 байна.	100
	1.3	Төрийн албан хаагчийн харилцаа хандлагыг дээшлүүлэх ёс зүйн сургалтад хамруулах.	Улсын төсөв 0,500,0	Ёс зүйн сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	541	550	Аймгийн эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хяналтын хороотой хамтран "Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сургалтыг зохион байгуулж нийт 375 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамрууллаа. Эрүүл мэндийн газрын НЭМХ-ийн даргыг 2 өдрийн төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад, эмч,	100

							эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах ажлын хүрээнд сумын эрүүл мэндийн төвийн 130 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” сэдвээр цахим сургалт, Дэлгэрцогт сумын эрүүл мэндийн төвөөс гомдол санал ирсэний дагуу “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ээр 15 мэргэжилтэнд, “Хандлагаа өөрчлө-Хамтдаа хөгжье” аяны хүрээнд эрүүл мэндийн газрын 29 төрийн албан хаагч нарт хандлага, ёсзүйн сургалтыг тус тус зохион байгууллаа. Нэгдсэн эмнэлгийн хэсгийн хороо нь шинээр ажилд орсон 11 хүнээс ёсзүйн мэдлэг шалгах сорил авч зөвлөмж өглөө. Нийт 562 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн сургалтад хамрагдлаа.	
1.4	ZOOM программаар эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдтэй видео хурал болон сургалтыг зохион байгуулах.	-	Цахим сургалтын тоо	56	60	Харъяа эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд цаг үеийн мэдээ мэдээлэл болон мэргэжил аргагүйн чиглэлээр цахим хурал сургалтыг нийт 64 удаа зохион байгуулж нийт давхардсан тоогоор 487 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.	100	
			Хамрагдсан албан хаагчдын тоо	220	250	430 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.		
1.5	“Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн хэрэгжилт, журам, стандартыг эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга нар болон байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад сургалт зохион байгуулах.	-	Хамрагдсан мэргэжилтний тоо	34	42	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон стандарт, холбогдох журмын талаарх сургалтыг аймгийн Архивын тасагтай хамтран Эрүүл мэндийн газрын удирдлага болон хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд танхимаар, эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга нар болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдах ажилтнуудад цахимаар зохион байгуулж сургалтад 57 хүн оролцлоо.	100	
<b>Зорилт</b>	2	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хийх хяналт шинжилгээ үнэлгээний давтамжийг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 1,8 сая	Давтамжийн тоо	1	2	Эмнэлгийн удирдлага зохион байгуулалт, санхүү, хүний нөөц, мэдээ мэдээлэл, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, магадлан итгэмжлэл гэсэн чиглэлээр 3 давтамжтайгаар хяналт үнэлгээг хийлээ.	100

<b>Арга хэмжээ</b>	2.1	Эмнэлэг, эрүүл мэндийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, зөвлөн туслаж ажиллах.	Улсын төсөв 1,8 сая	Хяналт үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	14	17	Эмнэлгийн удирдлага зохион байгуулалт, санхүү, хүний нөөц, мэдээ мэдээлэл, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр хяналт үнэлгээг давхардсан тоогоор 17 сумын эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулаад байна. Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийн тайланг хүлээн авсан.	100
	2.2	2022 онд магадлан итгэмжлэгдэх эрүүл мэндийн байгууллагуудад магадлангийн бэлтгэл ажлын үнэлгээ хийх.	Улсын төсөв 2,8 сая	Хяналт үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	2	13	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Магадлан итгэмжлэх лицензийн албатай хамтран “Эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлэлд бэлтгэх нь” сэдэвт сургалтыг нийт 50 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгууллаа. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/179 дүгээр тушаалын дагуу өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр 2022 онд магадлан итгэмжлэлд хамрагдах 13 сумын эрүүл мэндийн төвүүдэд хяналт шинжилгээ үнэлгээг хийж зөвлөн тусалж, цахим программд 22 үндсэн шалгуур үзүүлэлтийг хэрхэн оруулах талаар зааварчилгаа өгч сурган дадлагажууллаа. Дээрх сумдад магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 75-80 хувийн биелэлттэй байсан бөгөөд нийт 13 эмнэлэг магадлан итгэмжлэлт хамрагдлаа.	100
<b>Зорилт</b>	3	Хог хаягдлын менежментийг хэрэгжилтийг 2021 онд 91,0 байсныг 2022 онд 93,0 хувьд хүргэнэ.	Улсын төсөв 1,2 сая	Хэрэгжилтийн хувь	91,0	93,0	Хог хаягдлын менежментийг хэрэгжилт 93,5 хувьд хүрсэн.	100
<b>Арга хэмжээ</b>	3.1	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг төрлөөр ялган байршуулах.	Улсын төсөв 1,2 сая	Төрлөөр байршуулсан хогийн савны тоо	0	2	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах 3 тасалгаатай савыг хийж байгууллагын гадна талд байршуулсан.	100
	3.2	Ил задгай хог хаягдал хаяхгүй байх санамжийг байгууллагын гадна байршуулах.	Улсын төсөв 0500,0	Санамжийн тоо	1	10	Хог хаягдлыг 3 төрлөөр буюу цаас, хувцанцар, бусад хог ангилалаар ялгах болон ил задгай хог хаяхгүй байх санамжийг 12 ширхэгийг хэвлүүлэн байгууллагын гадна болон дотор талд байршуулсан.	100

	3.3	Ангилан ялгасан хатуу хог хаягдлыг борлуулах аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулан ажиллах.	Улсын төсөв 0,50,0	Гэрээ байгуулсан эсэх /тийм-1, үгүй 2/	0	1	Аймгийн хэмжээнд дахивар хог хаягдал авдаг “Баялаг” төвтэй хамтран ажиллах гэрээг байгуулж, “Баялаг” төвөөс байгууллагын ажилчдад дахивар хог хаягдлыг ангилан ялгах сургалтыг зохион байгуулж нийт 22 ажилчид хамрагдсан.	100
<b>Зорилт</b>	4.	2022 онд байгууллагын гадна талын 80 хувьд ногоон байгууламж бий болгосон байна.	Улсын төсөв 1,8 сая	Ногоон байгууламжийн хэмжээ /мкв/	100	220	Байгууллагын зүүн тал, урд хойд талуудад мод зүлэг суулгаж 90 хувийг ногоон болголоо. Ногоон байгууламжийн хэмжээ 250 м <sup>2</sup> болсон.	100
<b>Арга хэмжээ</b>	4.1	Байгууллагын гадна хашаанд 2-3 нэр төрлийн модыг шинээр тарьж нэмэгдүүлэх.	Улсын төсөв 1,0 сая	Тарьсан модны тоо	182	23	Байгууллагын гадна хашаанд 2 төрлийн 35 ширхэг модыг тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүллээ.	100
	4.2	Байгууллагын гадна талыг зүлэгжүүлэх	Улсын төсөв 0,800,0	Зүлэгжүүлсэн газрын хэмжээ /мкв/	50	180	Байгууллагын гадна талын хашаанд 200м <sup>2</sup> газрыг зүлэгжүүллээ.	100
	4.3.	Аймгийн хойд хэсэгт мод тарьж, элс цөлжилтөөс хамгаалах.	-	Тарьсан модны тоо	0	100	Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газраас чиглэл болгосны дагуу 300 ширхэг модыг салбарынхаа хэмжээнд тарьж 7 хоногт 2 удаа усалж байна.	100
<b>Зорилт</b>	5.	Цахим засаглалын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын цахим ашиглалтыг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 3,0 сая Төсөл 4,2 сая	Цахим ашиглалтын хувь	50,0	90,0	<b>Цахим засаглал шилжилтийн хүрээнд:</b> Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэлийн цахим, UPTODATE платформ, тусгай зөвшөөрлийг цахим, Зүрх судасны нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (МонПЕН) төслийн хүрээнд Зүрх судасны MNCARDIO программ хангамж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн E-hospital программ, эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн цахим программ, эрүүл мэндийн ажилтын нэгдсэн бүртгэлийн сан программыг тус тус нэвтрүүлэн хэрэгжүүлж цахим ашиглалт 95 хувьд хүрсэн. E-Mongolia аппликэйшн болон ТҮЦ машинаас эмнэлгийн цахим магадлан, вакцинжуулалтын цахим гэрчилгээг авч байна.	100

Арга хэмжээ	5.1	2 дахь шатлалын эмнэлэгт эмнэлгийн хуудас буюу листийг цахимд шилжүүлэх.	-	Цахимд шилжүүлсэн эмнэлгийн тоо	0	1	Лавлагаа шатлалын эмнэлэгт эмнэлгийн хуудас буюу листийг цахимд шилжүүлэхэд шаардлагатай мэдээллийг гарган Эрүүл мэндийн яаманд хүргүүлж Нэгдсэн эмнэлэгт цахим лист бичих ажил онлайн хэлбэрт шилжсэн. Цахим лист бичиж буй лавлагаа шатлалын эмнэлгийн тоо 1 болсон.	100
	5.2	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад E-HOSPITAL программыг нэвтрүүлэх.	Дэлхийн банк 1,7 сая	Программ нэвтүүлсэн байгууллагын тоо	0	17	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн E-HOSPITAL программыг нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглан иргэдийн эрт илэрүүлгийн үзлэгийг бүртгэж байна. Программын цахим сургалтыг эрүүл мэндийн ажилтнуудад 5 удаа зохион байгуулж, нийт 17 сумын эрүүл мэндийн төвүүдэд ашиглаж байна.	100
	5.3	Зүрх судасны өвнийг эрт илрүүлэх хянах “МН кардио” программыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлэх.	ДЭМБ 1,5 сая	Нэвтрүүлсэн эмнэлгийн тоо	0	17	Зүрх судасны өвчнийг эрт илрүүлэх хянах “МН кардио” программыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлж, сургалтыг үе шаттай зохион байгуулан явцын хяналт шалгалтыг 8 суманд хийлээ. Нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо 17	100
	5.4	Epr.e-mongolia ашиглалтын сургалтыг эрүүл мэндийн удирдах ажилтнуудын дунд зохион байгуулах.	-	Хамрагдсан удирдах ажилтны тоо	13	40	Аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөр 54 удирдах ажилтнуудад E-Mongolia академи болон аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран “ERP, E-mongolia программ”-ийн хэрэглээ сэдвээр сургалт мэдээлэл хийлээ.	100
	5.5	Эрүүл мэндийн байгууллагуудад “Эрүүл мэндийн салбарын ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” программыг нэвтрүүлэх.	Улсын төсөв 2,3 сая	Программ ашиглаж буй эмнэлгийн тоо	0	54	Эрүүл мэндийн байгууллагуудад “Эрүүл мэндийн салбарын ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” программыг нэвтрүүлж нийт төв хувийн хэвшлийн 71 байгууллагын 746 эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын 100 хувь нэгдсэн програмд бүртгэлээ. Программ ашиглаж буй эмнэлгийн тоо 71	100

<b>Зорилт</b>	6	Байгууллагын соёлыг дээшлүүлж, тохижилтийг орчны сайжруулна.	Улсын төсөв 7,9 сая	Орчны тохижилтын хувь	45,0	90,0	Байгууллагын соёлыг дээшлүүлэх жил болгон зарлаж зорилт жилийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 46 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 92,3 хувьтай байна. Орчны тохижилтийг сайжруулах зорилгоор байгууллагын гадна талд 35 ширхэг мод тарьж, зүлэгжүүлэн, модонд гэрэлтүүлэг хийлээ. Орчны тохижилт 90,0 хувьтай байна.	100
<b>Арга хэмжээ</b>	6.1	Байгууллагын гадна болон ногоон байгууламжийн хашаанд гэрэлтүүлэг хийх.	Улсын төсөв 3,8 сая	Гэрэлтүүлэг хийсэн эсэх /Тийм-1, Үгүй -2/	0	1	Байгууллагын гадна талд гэрэлтүүлэг хийж, ногоон байгууламжид гэрэлтүүлэг хийлээ.	100
	6.2	Байгууллагын гадна өнгийг шинээр будах	Улсын төсөв 1,5 сая	Шинээр будсан эсэх /Тийм-1, Үгүй -2/	0	1	Байгууллагын гадна өнгийг будах ажлыг эрчимжүүлэн Сайнцагаан сумын ЗДТГ-аас будгийн кодыг авч бүрэн шинээр будаж өнгө үзэмжийг сайжруулсан.	100
	6.3	Гадна талд машины зогсоолыг шинээр хийх.	Улсын төсөв 1,0 сая	Зогсоол хийсэн эсэх /Тийм-1, Үгүй -2/	0	1	Байгууллагын гадна талын машины зогсоолыг хусаж цэгцлэн хайрга асгаж борооны ус тогтохооргүй болгов.	100
	6.4	Байгууллагын орох хэсэгт угтах үйлчилгээ бий болгох.	Улсын төсөв 3,7 сая	Угтах үйлчилгээ бий болгосон эсэх /Тийм-1, Үгүй -2/	0	1	Байгууллагын орох гарах хэсэгт Угтах үйлчилгээг бий болгож байгууллагын жижүүр сууж орсон гарсан иргэдийг бүртгэлжүүлж байна.	100
<b>Зорилт</b>	7	Хүний хөгжлийг дэмжин ажиллана.	Улсын төсөв 5,5 сая	Иргэдийн сургалтад хамрагдсан тоо	45150	26750	59 удаагийн сургалтаар нийт давхардсан тоогоор 56029 хүнд эрүүл мэндийн боловсрол олгосон байна.	100
<b>Арга хэмжээ</b>	7.1	Дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэн "Илүүдэл жингүй Эртэч монгол" аян зохион байгуулах.	Улсын төсөв 1,2 сая	Аянд хамрагдсан иргэдийн тоо	0	1500	Аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран "Илүүдэл жингүй Эртэч Монгол" 3 сарын аяныг зохион байгууллаа. Аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн 12632, иргэд 7461, нийт 20093 хүн	100

				Дасгал хөдөлгөөнөөр хичээллэж буй иргэдийн тоо	25	85	бүртгүүлэн давхардсан тоогоор аяны турш 34179 хүн хамрагдсан байна. Дасгал хөдөлгөөнөөр хичээллэж буй иргэдийн тоо 105 байна.	
7.2	Иргэдэд хорт зуршлын хор уршигаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Архигүй амьдралыг цогцлооё” аянг зохион байгуулах.	Улсын төсөв 1,3 сая	Сургалтын тоо	0	5	Аймгийн Засаг даргаар удирдамж зааврыг батлуулан сум, байгууллага аж ахуй нэгжүүдэд хүргүүлэн “Архигүй амьдралыг цогцлооё-2” аяныг зохион байгуулан ажиллаж байна. Аяны хүрээнд “Мэргэжилтний баг”-ийг аймаг, сумдын хэмжээнд байгуулан тус бүр төлөвлөгөөг гарган үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. Архины хор уршиг, архинаас татгалзах мэдээлэл сургалт, нөлөөллийн арга хэмжээг 5 удаа зохион байгуулж 385 хүнийг хамруулсан.	100	
			Аянд хамрагдсан иргэдийн тоо	0	250			
7.3	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлж, эрүүл зан үйл, хандлага, дадлыг төлөвшүүлэх,	Улсын төсөв 2,0 сая	Хамрагдсан иргэдийн тоо	45150	50000	Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу “Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Эрчүүдээ хайрлая”, “Давсны хэрэглээгээ багасгая”, “Идэвхтэй дасгал хөдөлгөөний ач тус”, “Архи, тамхи хорт зуршлаас татгалзъя”, “Сүрьеэтэй тэмцэх”, “ДОХ-ын өдөр” “Эрүүл мэндийн сар”, “Коронавирусын халдвар, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцины ач холбогдол” зэрэг өдрүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 18350 хүнд мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 59 удаа сургалт зохион байгууллаа. Иргэдэд эрүүл амьдралын зөв зан үйл төлөвшүүлэх зорилгоор “Илүүдэл жингүй Эртэч Монгол” 3 сарын аян, “Зөвийг хэвшүүлье” 45 хоногийн аянд байгууллага, аж ахуй нэгж, холбоо, клубийн давхардсан тоогоор 37679 иргэнийг хамруулан, нийт давхардсан тоогоор 56029 хүнд эрүүл мэндийн боловсрол олгосон байна.	100	
			Сургалтын тоо	20	30			

7.4	“Замын хөдөлгөөний цагаан толгой” сэдэвт хүүхдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах.	-	Оролцсон хүүхдийн тоо	0	96	Хүүхдийн аюулгүй байдал эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, эрүүл мэнд, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой “Зөвийг хэвшүүлье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Боловсролын газар, Улаан-загалмайн нийгэмлэгтэй хамтран	100
						“Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг Сайнцагаан сумын 8 цэцэрлэгийн дунд зохион байгуулж 178 хүүхэд хамрагдлаа.	
7.5	Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх.	ЭМДСан 94,6 сая	Илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн хувь	64,9	65,0	Зорилтот насны иргэдийг хамруулах үзлэгийн үйл ажиллагааг 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс аймгийн хэмжээнд эхлүүлж 2022 оны байдлаар 6 бүлэг насны багцын үзлэгт 25300 хүн хамрагдахаас насанд хүрэгчдийн 4 багц үзлэгт 4231, 0-18 насны 2 багц үзлэгт 12467 хүүхэд хамрагдаж хамрагдвал зохих нийт иргэдийн 66,0 хувийг эзэлж байна.	0
7.6	Байгууллагат хүүхэд саатуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэргээр эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх.	УТ 1.5 сая Хандив тусламж 0675,0 мянга	Хүүхэд хөхүүлэх цэгтэй болсон эсэх /тийм 1, Үгүй 2 /	0	1	Байгууллага, ажилчдын хамтын 2,2 сая төгрөгийн санхүүжилтээр албан хаагчдын хүүхдүүдийг аав, ээжийнхээ ажил дээр байх хугацаанд амрах, тоглох, хичээлээ хийх нөхцөлийг хангаж ээлтэй орчинг бүрдүүллээ. “Хүүхдийн өрөөг” тохижуулан байгууллаа. Нийт 35 хүүхэд хамрагдлаа. Өрөөний нэг буланд хүүхэд хөхүүлэх цэг байгуулсан.	100
			Ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх /Тийм 1, Үгүй 2/	0	1		
			Хамрагдсан хүүхдийн тоо	0	4		
7.7	Эрүүл мэндийн сайдын 340 дугаар тушаалын дагуу албан байгуулага, аж ахуйн нэгжүүдтэй урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах гэрээ байгуулж, үзлэгт	Улсын төсөв 5,6 сая	Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо	1150	1500	Ажил олгогчид нь өөрсдийн ажилтнуудыг үзлэгт хамруулах хүрээнд 47 байгууллагын 963 ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан давхардсан тоогоор 1926 үзлэг шинжилгээ хийж 601 өвчлөл илэрсэн бөгөөд Хоол боловсруулах тогтолцооны өвчлөл зонхилж байгаа бөгөөд нийт үзлэгт хамрагдсан	80.7



	хамруулж, эрүүлжүүлэлтийг тооцож ажиллах.		Эрүүлжилтийн хувь	30.0	35.0	иргэдийн 85.0 хувьд эрхтэн тогтолцооны эмгэг илэрсэн байна. Өвчлөл илэрсэн иргэдийг хяналтад авч 3 дахь шатлалын эмнэлэгт 4 иргэнийг шилжүүлэн эмчилсэн. Эрүүлжилтийн хувь 61.4	
<b>13 Зорилтын хэрэгжилтийн дундаж</b>							<b>100</b>
<b>46 Арга хэмжээний дундаж</b>							<b>94.07</b>
<b>Хэрэгжилтийн дундаж</b>							<b>97.0</b>

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН: ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
(албан тушаал)

Ц.МӨНХБАТ

(гарын үсэг)

(огноо)

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
(албан тушаал)

*B. Altantog*

Б.АЛТАНТӨГС

(гарын үсэг)

огноо)

2022.12.12